



Цахим аюулгүй байдал

Иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан сургалт

Тодорхойлолт

Нийтийн мэдээллийн тухай хууль

4.1.9. "цахим баримт бичиг" гэж мэдээллийн системийг ашиглан үүсгэх, боловсруулах, хадгалах, илгээх болон хүлээн авах боломжтой мэдээллийг [хэлнэ]

4.1.1. "мэдээллийн систем" гэж мэдээлэл цуглуулах, боловсруулах, хайх, илгээх, хүлээн авах, ашиглах болон аюулгүй байдлыг хангах зорилго бүхий программ хангамж, техник хангамж, мэдээллийн сан, бусад бүрэлдэхүүн хэсэг, тэдгээрийн иж бүрдлийг [хэлнэ].

Харилцаа холбооны тухай хууль

3.1.14. "мэдээллийн технологи" гэж компьютер, харилцаа холбооны сүлжээ ашиглан цахим өгөгдлийг үүсгэх, боловсруулах, хадгалах, дамжуулах, солилцох, үйлчилгээ үзүүлэх, бусад тоног төхөөрөмжтэй холбогдох үйл ажиллагааны хооронд мэдээлэл илгээх, дамжуулах, хүлээн авах программ хангамж болон техник хэрэгслийн иж бүрдлийг [хэлнэ].

Сургалтын үндсэн 2 хэсэг



01

Цахим халдлага, гэмт хэрэг гэж юу болох

02

Цахим аюулгүй байдлаа хангах ур чадварууд




01

Цахим халдлага, гэмт хэрэг гэж юу болох


Цахим халдлага, гэмт хэргийн талаарх ойлголт



Цахим гэмт хэрэгтэн бодит амьдрал дээр



Цахим халдлагын жишээ



WARNING!


SYSTEM MAY HAVE DETECTED VIRUSES ON YOUR COMPUTER

System May Have Found (2) Malicious Viruses: **Rootkit.Sirefef.Spy** and **Trojan.FakeAV-Download**. Your Personal & Financial Information **MAY NOT BE SAFE**.

For Help Removing Viruses, Call Tech Support Online Right Away:

1(855) 970-1892
(TOLL-FREE, High Priority Call Line)

Your IP Address: | Generated on 02-18-2014 | Priority: Urgent



Цахим гэмт хэрэгтний зорилго



- ❖ Хувийн мэдээллийг олзлох
 - Нэр, регистрийн дугаар, хаяг, банкны мэдээлэл
 - Хэрэглэгчийн нэр, нууц үг
- ❖ Байгууллагын дотоод/нууц мэдээллийг олж авах
 - Дотоод мэдээлэл, ажиллаж байгаа асуудал
- ❖ Хувийн зураг зэргийг олзлон, сүрдүүлэх
 - Заримдаа улс төрийн зорилготой ч ихэнх нь мөнгө олох зорилготой

Цахим Монгол: тоо баримт

2022 оны 1 дүгээр сарын байдлаар:

- нийт хүн ам 3.6 сая
- интернэт хэрэглэгч 2.16 сая
- нийгмийн сүлжээний хэрэглэгч 2.85 сая (хүн амын 85 хувь)
 - жилд 96,0 мянган (хүн амын 4.7 хувь) хүнээр нэмэгдэж байна (2021-2022 оны судалгаа)
- Монголын нийт нутаг дэвсгэрийн 65 хувьд интернэт нэвтэрсэн

Эх сурвалж: *Digital 2022: Mongolia* <https://datareportal.com/reports/digital-2022-mongolia>



02

Цахим аюулгүй байдлаа хангах ур
чадварууд

Цахим халдлагын төрөл хэлбэр

- вирус
- фишинг/phishing халдлага буюу “дэгээ хаях” арга
- нууц үг тааруулах
- дундын этгээд буюу нэр хүнд бүхий байгууллага, хүний дүрд тоглох
- Drive-by downloads буюу хэрэглэгчийн зөвшөөрөлгүй программ суулгах
- үйлчилгээг хаах буюу байгууллагын вебээр үзүүлдэг үйлчилгээг барьцаалах
- нийгмийн инженерчлэл буюу сэтгэл зүйгээр ‘тоглох’ (нэг хэлбэр нь цахим залилан)

Цахим халдлагын дийлэнх нь хэрэглэгч өөрөө нэвтрэх боломжийг олгосон, нууц үг зэрэг хувийн мэдээллээ хэлж өгсөн зэрэгтэй холбоотой байдаг.

Өөрийгөө хэрхэн хамгаалах вэ?

Цахим аюулгүй байдал

Төхөөрөмжөө халдлагаас хамгаалах
Интернэтэд холбогдоход ашигладаг
төхөөрөмж, сүлжээ, программ
хангамжийн хамгаалалтыг хэрхэн хийх
тухай мэдлэг, мэдээлэл

Заль мэхийг таньж мэдэх
Цахим гэмт хэрэгтнүүдийг ашигладаг
арга мэх, тэдгээрт хэрэглэгч өртөх
эрсдэлт алхам хийхгүй байхад туслах
мэдлэг, мэдээлэл

Цахим аюулгүй байдлын ур чадвар

Цахим аюулгүй байдал

Төхөөрөмжөө халдлагаас хамгаалах

- Биет хамгаалалт
- Программ хангамжийн хамгаалалт
- Интернэтийн аюулгүй байдал
- Сайн нууц үг
- Фишинг урхины шинж тэмдгүүд
- Өгөгдлийг хамгаалах back up

Заль мэхийг таньж мэдэх

- нийгмийн инженерчлэл буюу хэрэглэгчийн “сэтгэл зүйгээр тоглох” арга тактик
- хариуцлагатай хэрэглэгч

Төхөөрөмж, программ хангамж

1. Биет хамгаалалт = төхөөмжөө алдахаас сэргийлж хараа хяналттай байлгах

2. Программ хангамжийн аюулгүй байдал = вирус авахаас хамгаалах

➤ Баталгаатай буюу **лицензтэй** программ хангамж ашиглах

- Сайн тал нь найдвартай, тогтмол шинэчлэгдэн (update) хамгаалалт нь сайжирна
- Сул тал нь ТББ, хувь хүний хувьд өндөр үнэтэй

➤ Лицензтэй программ хангамж боломжийн үнээр олж авах арга зам:

- “TechSoup” олон улсын байгууллага (хөөцөлдөх хэрэгтэй)
- Window доторх “Microsoft Store” цахим дэлгүүр (зарим апп нь төлбөртэй)
- Нээлттэй лицензтэй (Open source) программууд (үндсэн эх сурвалж вебээс татах)
- Windows** программын өөрийнх нь хамгаалалтын систем “**Defender**”-ийг идэвхжүүлэх

Интернет

Браузер = [Google Chrome](#), [Mozilla Firefox](#), [Internet Explorer](#) зэрэг хөтөч

- Remember History - үзсэн хуудаснуудын хаягийг хадгална
- Private Browsing/Incognito/SHIFT+CTR+N = нууц мэдээлэл, онцгой асуудлаар хайлт хийх бол энэ тохиргоог ашиглахад мэдээлэл хадгалагдахгүй
- Save Password- цахим халдлагад өртвөл нууц үг алдагдах эрсдэлтэй тул “Нууц үг хадгалах уу?” гэж асуухад “Үгүй” гэсэн хариуг сонго.

Интернэтийн сүлжээ = WiFi

| Хамгаалалтгүй сүлжээ | Хамгаалалттай сүлжээ |
|--|--|
| Дамжуулж байгаа мэдээлэл хамгаалалтгүй. Үнэгүй WiFi нь хамгаалалтгүй сүлжээ | Дамжуулж байгаа мэдээлэл шифрлэгдэж, зорилтот талдаа хүрсэн үед шифр нь текст болж тайлагдана |

Сайн нууц үг

Сайн нууц үг ямар байх талаарх *сүүлийн үеийн* зөвлөмж (хэсэг хугацааны дараа өөрчлөгдөж мэднэ)

- 16+ тэмдэгттэй байх
- Том болон жижиг үсэг заавал орох
- Тэмдэг орсон (@#\$%^&*)
- Өгүүлбэр хэлбэрээр зохиовол сайн

Таны нууц үг хэр сайн бэ?

1. Нууц үг зохио
2. <https://www.passwordmonster.com/> руу ор
3. Зохиосон нууц үгээ оруулж шалга
4. Хэр сайн нууц үг байна вэ?

Хоёр шаттай баталгаажуулалт

Нууц үгний хүчийг нэмэгдүүлэх *2 алхамтай нууц үгийн систем*


- 1) хэрэглэгч нууц үгээ оруулна
- 2) бүртгэлтэй гар утас руу код ирнэ
- 3) уг кодыг оруулснаар уг нууц үгний эзэн мөн гэдгээ баталгаажуулна.

Жишээ: e-mongolia

! 2 шаттай баталгаажуулалтыг идэвхжүүлэх хүсэлтэй оролцогчдод тусгайлан цахимаар зааварчилгаа өгч болно.

Фишинг буюу урхи хаях арга

Англи хэлний *fishing* = загасчлах үгтэй ижил дуудлагатай



Фишинг жишээ: имэйл

Google Support

Хэнээс: "Google Support" <support@google.com>

Агуулга: Та яаралтай нууц үгээ шинэчилнэ үү.

Сайн байна уу,

Таны бүртгэлийн нууц үгийн хугацаа 24 цагийн дотор дуусах тул яаралтай доорх холбоосоор нэвтэрч шинэчилнэ үү!!!

[Нууц үгээ солих](#)



One account. All of Google.

Sign in to continue to Gmail



Next

[Need help?](#)

Дата backup

- Чухал файлуудаа аливаа эрсдэлээс сэргийлж өөр нэг газар хадгалахыг дата backup буюу өгөгдлөө нөөцөлж болно.

- Backup хийх 3 арга



```
graph LR; A[Backup хийх 3 арга] --> B[Үүлэн технологи]; A --> C[Өөр компьютер дээр хадгалах]; A --> D[Зөөврийн хард, флаш дээр хуулах];
```

Үүлэн технологи

Өөр компьютер дээр хадгалах

Зөөврийн хард, флаш дээр хуулах

Нийгмийн инженерчлэл буюу сэтгэл зүйгээс ТОГЛОХ

- Фейсбүүкээр хүнтэй танилцаж, тодорхой хугацаанд найзлан дотносож, итгэлийг нь олж авсны дараа мөнгө гуйх
 - Гэрлэх санал тавьсны дараа осолд орсон гэж мөнгө авсан
- Нийгмийн сүлжээгээр танилцаж, хувийн зураг, бусдад мэдэгдэхийн хүсэхгүй мэдээллийг олж аваад, түүнийгээ барьцаалах
 - Хувийн зургийг нь аваад, дарамталсан
- Утсаар:
 - хүүхэд нь осол хийсэн тул мөнгө шилжүүлээд хэрэг нээхгүй байх санал
 - Гадаадын дуудлага тасарсан тул эргээд залгах

Хариуцлагатай / хэрсүү цахим хэрэглэгч

- **Цахим сүлжээнд санаа бодлоо бичиж нийтлэхээс өмнө эргэж харах.** Сэтгэлийн хөдөлгөөнөөр, сайн бодож амжаагүй зүйл нийтлэх эрсдэлтэй
- **Нийгмийн сүлжээнд та нэр, усгүй үл үзэгдэгч биш.** Цахим ертөнцөд таны нийтэлсэн зүйл алдар нэрд нөлөөлнө. Хэзээ ч устаж алга болохгүй
- **Хуурамч, бодитой бус мэдээлэл тараахад оролцохгүй байх.** Сэтгэл хөдлөлөөр, эх сурвалж болон зорилгыг нь эргэцүүлэлгүй шууд share хийж бусдад түгээх нь эрсдэлтэй.
- **Нийгмийн сүлжээнд хүнтэй танилцахдаа болгоомжтой, ухаалаг хандах.** Цахим орчинд ямар хүмүүстэй найз болох, ямар захидалд хариулж холбоо тогтоох талаар тогтох бодоорой.
- Цахим халдлагаас гадна хэрэглэгч алдаа гаргаж, нууц мэдээллээ өөрөө хуваалцах нь бий.

Дүгнэлт 1: Цахим халдлага, гэмт хэрэгт хэн ч өртөж болно

Ухаалаг төхөөрөмж ашиглан интернэтэд орж байгаа хэн ч гэсэн цахим халдлагад өртөх магадлалтай. Цахим халдлагын нийтлэг хэлбэрүүд: хувийн мэдээлэл олзлох элдэв урхи, төхөөрөмж рүү нэвтрэх боломжийг хайсан фишинг, СПАМ, вебсайт, хавсралт

Дүгнэлт 2: Хүн бүр цахим халдлагаас өөрийгөө хамгаалах боломжтой

- ухаалаг төхөөрөмжийн биет аюулгүй байдал, сүлжээний хамгаалалтыг хийх
- 2 алхамт баталгаажуулалт хийж, сайн нууц үгтэй байх
- нийгмийн инженерчлэлийн тухай ойлголттой байх

Дүгнэлт 3: Хариуцлагатай, мөн хэрсүү хэрэглэгч байх

- Цахим аюулгүй байдлын үр чадваруудаа амьдралдаа хэрэгжүүлэх
- Интернэтэд нийтэлсэн сэтгэгдэл, пост хэзээ ч устахгүй, хэзээд таны нэртэй холбоотой байх тул хариуцлагатай, ёс зүйтэй байх
- сэтгэлийн хөдөлгөөнөөр, яарч, цаад зорилгыг нь нягтлахгүйгээр мэйлд хариулах, линк дарах, хувийн мэдээлэлээ өгөх, мэдээлэл дамжуулахгүй байх
- цахим залилангийн талаар сэрэмжтэй байж, хэрсүү хандах